



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН
2022

Эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны хамтын ажиллагааны гэрээний үнэлгээний дүн, зөвлөмж

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЖАРГАЛ

Гэрээг дүгнэх ажлын зохион байгуулалт

Аймгийн Засаг даргын 2017 оны А/324 дүгээр захирамж



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017-06-14

Дугаар: А324

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, 29.2, Монгол улсын "Эрүүл мэндийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, "Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	А.Өнөржаргал-Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	О.Энхбаяр -Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн П.Хишгээ-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Мөнхбаяр-Эрүүл мэндийн Сум өрхийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн О.Батцэнгэл-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл хариуцсан мэргэжилтэн Э.Тунгалагтуяа-Эрүүл мэндийн газрын Халдварын тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн Б.Цэндбаяр-Эрүүл мэндийн газрын БЗДХ, сүрьеэгийн тандалт, сэргийлэлт, өсвөр үе,залуучуудын эрүүл мэнд хариуцсан ажилтан А.Баярхүү –Эрүүл мэндийн газрын Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Жаргалсайхан-Өрхийн анагаах ухааны Монголын холбооны тэргүүн Б.Батжаргал-Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Энхжаргал-Эрүүл мэндийн газрын НЭМХ-ийн дарга

2.Гэрээг дүгнэх үйл ажиллагаанд шаардагдах шатахууны зардал 500000 /Таван зуун мянган /төгрөгийг "Эмч дэд хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлэх зардлаас" гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н. Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэнд явцын хяналт хийх, хагас бүтэн жилээр дүгнэж, үр дүнг тооцож ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /н.Өнөржаргал/-д үүрэг болгосугай.

ЭМГД-ын 2021 оны А/02 дугаар тушаал



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04-ны өдөр

Дугаар А/02

Эрдэнэт

"Ажлын хэсэг байгуулах тухай"

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дэхь заалт, Монгол улсын "Эрүүл мэндийн тухай" хуулийн 12, 20 дугаар зүйл, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8.1 дүгээр заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай" 415 дугаар тушаалын 2.2, 3.2, 4.1 дэх заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, бусад холбогдох журам, стандарт, заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах болон хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг дүгнэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд явцын хяналт хийх, хагас бүтэн жилээр дүгнэж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



Гэрээг дүгнэх аргачлал (эрх зүйн үндэслэл)

1. ЭМБ-ын үйл ажиллагаанд ХШҮ хийх нийтлэг журам
(ЭМСайдын 2021 оны А/605 дугаар тушаал)
2. Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам
(ЭМСайдын 2021 оны А/578 дугаар тушаал)
3. ЭМС-ын 2017 оны А/05-ӨЭМТ-тэй байгуулах гүйцэтгэлийн гэрээг дүгнэх журам

Дотоод орчин	1. Гэрээний хэрэгжилтийн тайлагналт, заалт бүрээр 2. Хүний нөөц	4. ЭМТҮ-ний чанарын үзүүлэлтийн биелэлт /ЭМГ болон байгууллагын статистик/	Гадаад орчин
	3. Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилт	5. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, өргөдөл гомдлын мэдээлэл 6. Ажлын хэсгийн үнэлгээ, дүгнэлт	

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Захиалагч	Гүйцэтгэгч	Гэрээний төрөл	Он	
			2020	2021
Эрүүл мэндийн сайд	Аймгийн Засаг дарга	Гэрээ	94,5%	97,4%
Аймгийн засаг дарга	Эрүүл мэндийн газрын дарга			
Жаргалант сумын засаг дарга, ЭМГ-ын дарга	Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн дарга		92,5%	92%
Аймгийн Засаг дарга	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга	Гүйцэтгэлийн гэрээ	90,3%	88,4%
	Эрүүл мэндийн газрын дарга			
Эрүүл мэндийн газрын дарга	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга-12 эмнэлэг	Хамтын ажиллагааны гэрээ	88,5%	87,5%
	Эм ханган нийлүүлэх байгууллагын захирал, эрхлэгч -10		88,2%	89%



НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Үнэлгээний нэгдсэн дүнгээр салбарын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны хамтын ажиллагааны гэрээний дундаж үнэлгээ 89,2% буюу “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН” гэж үнэлэгдэв.

Энэхүү үнэлгээ нь зорилт нь шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДЛУУД

- Төлөвлөлт байгууллагын үндсэн чиг үүрэг, бодлогын баримт бичигтэй уялдаагүй.
- Тайлагналт албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангахгүй /товч тодорхой, үр дүнг илтгэсэн, 2000 тэмдэгт/
- Хугацаа хоцроосон.
- Хэрэглэгчийн үнэлгээг хугацаанд нь бүрэн өгөөгүй, хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгээгүй.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлтэд дүн шинжилгээг хийхгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Төлөвлөлтийг зөв хийх, төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан байх
- Шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлсон байх, шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэлд үндэслэсэн байх
- Тайлант жилд тухайн асуудлын хүрээнд гарсан өөрчлөлтийг (ахиц, дэвшил, бууралт) тодорхой гаргахын тулд тоон үзүүлэлттэй, харьцуулалт хийх зарчмаар тайлагнах
- Байгууллага бүр төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутам үнэлгээ хийж, биелэлт дутуу, хэрэгжээгүй арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах/шилжилт хөдөлгөөн -23%/
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэх, чадавхжуулах талаар анхаарч ажиллах
- Ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж эмчлэн эрүүлжүүлэх ажил зохион байгуулах, үр дүнг тооцох
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр сар бүр сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулж үр дүнг тооцдог байх.
- Хөндлөнгийн байгууллагаар эмнэлгийн тусламж үйлчилгээ болон сэтгэл ханамжийн үнэлгээг хийлгүүлэх-ЭМС-ын А/578 дугаар тушаал/

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, чанарыг сайжруулахад анхаарах
- Шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг өргөжүүлэх, үр дүнг тооцох
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын /шинэ болон сэргэж буй халдварт өвчин, хоолны хордлого, байгалийн гамшиг /-ын үеийн мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах, хариу арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөлт, дүгнэлт, судалгаатай ажиллах
- Байгууллагын дотоод хяналтын ажлыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх

- 2022.05.01-ээс хэрэгжиж эхлэх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах
- Байгууллагын мэдээллийн технологийн чадавхыг сайжруулж цахим вэб хуудасны үйл ажиллагааг эрчимжүүлж тогтворжуулах, мэдээ мэдээллийг байнга шинэчилж байх
- Төсвийн үр ашигтай байдал, ил тод байдлыг нэмэгдүүлэх



**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 11.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 195-196, 198-202 дахь зүйлийг тус тус үндэслэн:

Нэг талаас Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч С.Энхболд /цаашид "Захиалагч" гэх/.

Нөгөө талаас Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргал /цаашид "Хэрэгжүүлэгч" гэх/ нар энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь аймгийн Засаг даргад хууль тогтоомжоор олгосон нийтлэг бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан УИХ, Засгийн газар, УОК-оос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш хүртээмжтэй, чанартай, шуурхай байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү гэрээтэй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга), Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тус тус зохицуулна.

1.3. Гэрээний талууд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг сайжруулах, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнг санхүүжүүлэх зарчмыг баримтална.

1.4. Гэрээг хоёр эх хувь үйлдэв.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.1. Аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ.

2.1.2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тохиолдолд суурилсан тусламж, үйлчилгээний санхүүжилтийг гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

10.2. Гэрээний шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд Захиалагчаас гүйцэтгэчийг мөнгөн бус хэлбэрээр урамшуулна.

Арваннэг. Маргааныг шийдвэрлэх

11.1. Төлбөрийн шилжүүлэгтэй холбогдон үүссэн маргааныг Сангийн яаманд хандаж, зохицуулах арга хэмжээг авна.

11.2. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн маргааныг гэрээний талууд зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

11.3. Зөвшилцөлд эс хүрвэл шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Арванхоёр. Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

Арвангурав. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг

13.1. Энэхүү гэрээ нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

13.1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ;

13.1.2. Хавсралт 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт;

13.1.3. Хавсралт 2. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны төсөв;

13.1.4. Хавсралт 3. 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт;

13.1.5. Хавсралт 4. Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг тайлагнах загвар.

ЗАХИАЛАГЧ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

С. Энхболд

С.ЭНХБОЛД

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

С. Батжаргал

С.БАТЖАРГАЛ

2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр
Улаанбаатар хот



ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ-49

- Коронавируст халдварын цар тахлаас сэргийлэх тэмцэх

15

- Нийгмийн эрүүл мэнд

13

- Анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр

5

- Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр

8

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээний чиглэлээр

12

- Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилт

9

- Хүний нөөцийн чиглэлээр

7

- Бусад

8

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ-31

№	Үзүүлэлт	2021	2022
1	Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалтын хувь	54,0	64,0
2	Чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалтын хувь	68,3	78,3
3	Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалтын хувь	28,9	33,9
4	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	12898	13543
5	Урьдчилан сэргийлэх үзлэг	39,9	44,9
6	В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	99,2	Суурь үзүүлэлтээс доошгүй
7	Тавт сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	98,9	Суурь үзүүлэлтээс доошгүй
8	УГУ эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	99,1	Суурь үзүүлэлтээс доошгүй



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ



№	Үзүүлэлт	2021	2022
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд)	39,7	0
10	Тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	13,9	13,2
11	Нялхасын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	12,3	11,8
12	Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	10,3	9,8
13	Амьгүй төрөлтийн түвшин /1000 төрөлт тутамд/	4,4	3,9
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	96,8	99,8
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	10,8	9,8
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10000 хүн амд/	4,9	4,4
17	Вируст гепатитын өвчлөлийн түвшин, 10,000 хүн амд	0	0



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ



№	Үзүүлэлт	2021	2022
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд)	21,3	21,1
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд)	13,1	12,6
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10,000 хүн амд	1,1	0,9
21	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаадсан нас баралтын түвшин, 10,000 хүн амд	3,9	3,6
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин 10,000 хүүхдэд	11,7	10,7
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, 10,000 хүн амд	0,3	0,1
24	Шинээр авсан сувилагчийн тоо		Гүйцэтгэлээр
25	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
26	Хүний нөөцийг бүрдүүлэх 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ



№	Үзүүлэлт	2021	2022
27	Орон нутгаас байр, орон сууцаар хангасан эмч, мэргэжилтний тоо		Гүйцэтгэлээр
28	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан санхүүжилт /чиглэл, төгрөг, хувиар/		Гүйцэтгэлээр
29	Сувилагч мэргэжлээр тайлангийн жилд орон нутгаас зардлыг даан сургасан шинэ суралцагчийн тоо		Гүйцэтгэлээр
30	Хүний нөөцйн хөгжил, нийгмийн хамгааллыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр ЗД, ИТХ-ын түвшинд гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
31	Тайлангийн жилд орон нутгийн төсвөөс хүний нөөцийн чадавхийг сайжруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мян.төг/		Гүйцэтгэлээр



1. Анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх-Өрхийн эрүүл мэндийн төвийн менежментийг сайжруулах 2022-2023 оны хөгжлийн төлөвлөгөө
2. НЭМ- Суурь судалгаа хийх, судалгаа шинжилгээний ажлыг нийтийн хүртээл болгох, ЭМДТ
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ-Шинэ дэвшилтэт технологи, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх
4. Хүний нөөцийг чадавхжуулах- Эмч хөтөлбөр /Тоног төхөөрөмжийн ашиглалт, ажиллах чадварыг сайжруулах, гадаад хэлний боловсролд анхаарах, олон улсын түвшингийн “Up to date” платформыг ашиглалт/
5. Эрүүл мэндийн салбарыг цахимжуулах
 - ✓ Эрүүл мэндийн байгууллагуудыг шилэн кабельд үе шаттайгаар холбож, интернетийн хурдыг сайжруулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг хангах
 - ✓ Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг ил тод цахимжуулах, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах
6. Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 эрүүл мэндийн салбарт нэвтрүүлж эхлэх /ЭМГ, 1 ӨЭМТ/
7. Коронавируст халдвар /ковид-19/-ын шинэ хувилбарын тархлатаас урьдчилан сэргийлэх, тандалтыг эрчимжүүлэх, нийгмийн, эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах, нөөцийн бэлэн байдлыг хангах, хяналт тавих, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах
8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх





ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН
2022

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА